



# ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ

2022 ОНЫ IV УЛИРЛЫН ТҮҮВЭР  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.

## 1. ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ

Инфляцын талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг 2023 оны 1 дүгээр сарын 27-ноос 2 дугаар сарын 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 8 дүүргийн хэмжээнд нийт 1,030 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг хийж гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа.

- Иргэдийн өгсөн хариултаар инфляцын түвшнийг (хүлээлт) тооцвол:
  - 2023 оны I улирлын эцэст I) чанарын хариултаар **16.9%**, II) тоон хариултаар **9.8%**, III) мэдрэмжид суурилсан аргачлалаар **14.1%**;
  - 2023 оны IV улирлын эцэст I) чанарын хариултаар **12.5%**; II) тоон хариултаар **11.3%**; III) мэдрэмжид суурилсан аргачлалаар **11.1%** байхаар байна.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 28% нь 2023 оны IV улиралд инфляцын түвшинг зорилтот түвшнээс хэтрэхгүй гэсэн хүлээлттэй байна.
- Иргэдийн 96% нь өнгөрсөн 3 сард үнэ өссөн, 81% нь ирэх 3 сард үнэ өснө гэж хариуллаа.
- Эдийн засгийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлтийн утга өмнөх улирлаас нэмэгдэж, “өснө” гэсэн мужид хэвээр хадгалагдлаа.
- Ханшийн чиглэлийн индексийн утга “төгрөг суларна” гэсэн мужид хэвээр хадгалагдсан хэдий ч бага зэрэг буурах хандлагатай байна.
- 2020 оны эцсээс судалгаанд оролцогчдын ихэнх нь өрхийн санхүүгийн байдал муудаж байна гэсэн хариултыг өгч эхэлсэн бөгөөд энэ улиралд мөн иргэдийн хүлээлт муудна гэсэн мужид хэвээр хадгалагдлаа. Үүнд үнийн өсөлт голчлон нөлөөлж байна.
- Иргэдийн дийлэнх нь гол бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, дотоодын бизнес эрхлэгчдээ дэмжиж хамтран ажиллах, ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин өсгөх тал дээр хамгийн ихээр санал бодлоо илэрхийллээ.

Иргэдийн инфляцын хүлээлт



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

## 2. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Иргэдийн өгсөн хариултаар 2023 оны I улирлын (3 сарын дараа) инфляцын хүлээлтийг тооцоход тоон хариултын хувьд 9.8%, чанарын<sup>1</sup> хариултаар 16.9%, мэдрэмжид суурилсан /perceived inflation/<sup>2</sup> аргачлалаар 14.1%-тай байхаар гарсан байна /Зураг 2.1/.

Харин 2023 оны IV улиралд (1 жилийн дараа) инфляцын хүлээлтийн утга тоон хариултаар 11.3%, чанарын хариултын хувьд 12.5%, өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан аргачлалаар 11.1%-тай байхаар байна /Зураг 2.2/.

Иргэдээс ирэх 3 сард үнийн өсөлт ямар байх талаар төсөөллийг асууж, чиглэлийн индекс<sup>3</sup>-ийг тодорхойлоход “инфляц өснө” гэсэн мужид хэвээр хадгалагдав. Энэхүү үр дүнг өмнөх улиралтай харьцуулахад үнэ өснө гэсэн иргэдийн хандлага нэлээд буурсан байна /Зураг 2.3/.

Инфляцын хүлээлтийн чанарын хариултын хувьд иргэдийн 81% нь ирэх 3 сард үнийн түвшин өснө гэж үзсэн. Үүнээс 46% нь үнийн түвшин одоогийн түвшнээс илүү хурдацтайгаар өснө, 28% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй, 7% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурд буурна гэж хариулжээ /Зураг 2.4/.

Зураг 2.1 | Иргэдийн инфляцын хүлээлт /ирэх 3 сар/



<sup>1</sup> Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон.

<sup>2</sup> Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцын хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажил


Зураг 2.2 | Иргэдийн инфляцын хүлээлт /ирэх 12 сар/



Зураг 2.3 | Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс, ирэх 3 сар/



Зураг 2.4 | Ирэх 3 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?




<sup>3</sup> Өснө, буурна гэсэн хариултаудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ иргэдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултаудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.


Иргэдийн инфляцын хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляц ирэх 3 сард буюу 2023 оны I улиралд 9.8%, 12 сарын дараа буюу 2023 оны IV улиралд 11.3% байхаар хүлээгдэж байна. Тоон хариултын хувьд **ирэх 3 болон 12 сарын хугацаанд инфляцын хүлээлтийн утга зорилтот түвшин ( $6\pm 2\%$ )-ээс илүү байна** /*Зураг 2.5/.*

Инфляцын хүлээлтийн тоон хариултын хуримтлагдсан тархалтаас харахад 2023 оны I улиралд иргэдийн 31.8%, 2023 оны IV улиралд иргэдийн 24.6% нь инфляцын хүлээлтийн утга зорилтот түвшин болох 6%-иас хэтрэхгүй байна гэж хариулсан /*Зураг 2.6/.*

**Зураг 2.5 | Иргэдийн инфляцын хүлээлтийн тархалт /тоон хариултаар/**



**Зураг 2.6 | Иргэдийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/**



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

### 3. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТЭД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛ


#### Макро эдийн засгийн хүчин зүйл

**Эдийн засгийн өсөлт:** Манай улсын эдийн засаг 2022 оны III улиралд 3.7%, IV улиралд 4.8%-иар өссөн. Үүнтэй уялдан иргэдийн эдийн засгийн нөхцөл байдалд өгөх үнэлгээ бага зэрэг нэмэгджээ. Тухайлбал 2022 оны IV улирлын түүвэр судалгааны үр дүнгээр иргэд эдийн засгийн нөхцөл байдал ирэх 3 сард сайжирна гэсэн хүлээлттэй байна /*Зураг 3.1*/.

**Валютын ханшийн хүлээлт:** Төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш суларч 2022 оны IV улиралд 3402.54 төгрөг болж, өмнөх улирлаас 6.4 хувиар буурчээ. Валютын ханшийн талаарх чиглэлийн индекс өмнөх улиралд “төгрөг суларна” гэсэн хүлээлттэй байсан бол энэ улиралд мөн тус мужид хэвээр хадгалагдлаа. Гэвч өмнөх улиралд явуулсан судалгаатай харьцуулахад ханшийн хүлээлтийн индекс бага зэрэг буурах хандлагатай байна /*Зураг 3.2*/.

**Зээлийн хүүний хандлага:**<sup>4</sup> Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2022 оны 12 сарын эцсийн байдлаар өмнөх улирлаас 0.8 нэгж хувиар өсөж 15.2%-тай байна. Зээлийн хүүний талаарх иргэдийн хүлээлтийг авч үзэхэд ирэх 3 сард зээлийн хүү одоогийн түвшинд хадгалагдана гэж иргэдийн 41% нь үзэж байгаа бол 23% нь өснө, 10% нь буурна гэжээ. Зээлийн хүүний чиглэлийн индекс 2022 оны I улирлаас хойш “өснө” гэсэн мужид хэвээр байгаа хэдий ч энэ удаагийн судалгаагаар зээлийн хүү бага зэрэг буурна гэж хүлээх иргэдийн тоо нэмэгдсэн байна /*Зураг 3.3*/.

Зураг 3.1 | Эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Зураг 3.2 | Валютын ханшийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Зураг 3.3 | Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 3 сард/



<sup>4</sup> Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл оруулснаар)

### Микро эдийн засгийн хүчин зүйл

**Өрхийн орлогын хандлага:**<sup>5</sup> 2020 оны IV улирлаас эхлэн өрхийн бодит орлого буурсантай холбоотойгоор иргэдийн хүлээлтийн утга өрхийн орлого “муудна” гэсэн мужид шилжиж өнөөг хүртэл хэвээр хадгалагдлаа /*Зураг 3.4*/.


Судалгаанд оролцогч иргэдийн дийлэнх хэсэг болох **71%** нь **ирэх 3 сард өрхийн орлого өөрчлөгдөхгүй** гэсэн бол 7% нь өснө, харин 18% нь буурна гэж хариулжээ. Өрхийн орлого ирэх 3 сард буурна гэж хариулсан иргэдээс шалтгааныг тодруулахад 60% нь барааны үнэ өснө, 13% нь бусад орлого буурна, 8% нь ажилгүй, 8% нь бизнесийн орлого буурна, 7% нь цалин буурна, 3% нь тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө буурна гэж хариулжээ /*Зураг 3.5*/.

**Өрхийн хэрэглээний хандлага:** 2021 оны III улирлаас эхлэн иргэдийн хүлээлтийн утга өрхийн хэрэглээ “өснө” гэсэн мужид тогтмол хадгалагдаж байна /*Зураг 3.6*/.

2022 оны IV улирлын түүвэр судалгаанд оролцсон иргэдийн 32% нь өрхийн хэрэглээ ирэх 3 сард өөрчлөгдөхгүй гэсэн бол 36% нь нэмэгдэнэ, харин үлдсэн 28% нь буурна гэсэн хүлээлттэй байна. Өрхийн хэрэглээ ирэх 3 сард буурна гэж хариулсан иргэдийн 27% нь тэтгэврийн насныхан байна. Хэрэглээ буурна гэж хариулсан нийт иргэдийн 56% нь хадгаламжгүй бөгөөд 61.6% нь ирэх 3 сард зээлийн хэрэгцээ үүснэ гэж хариулжээ.

**Зээлийн хэрэгцээ үүсэх эсэх:** Ирэх 3 сард нэмэлтээр болон шинэ зээлийн хэрэгцээ үүсэх эсэх талаар асуухад судалгаанд оролцогчдын 62%-д нь зээлийн хэрэгцээ үүснэ, үлдсэн 38% нь зээлийн хэрэгцээ үүсэхгүй гэсэн хариулт өгчээ /*Зураг 3.7*/.

**Зураг 3.4 | Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт, өрхийн орлого /ирэх 3 сард/**



**Зураг 3.5 | Өрхийн орлого буурах шалтгаан**




**Зураг 3.6 | Өрхийн хэрэглээний талаарх хүлээлт /ирэх 3 сард/**



<sup>5</sup> Нэрлэсэн цалингийн индексийг 2015 оны сууриар тооцож бодит цалингийн индекст шилжүүлсэн үзүүлэлтийг харьцуулав.

Зураг 3.7 | Өрхийн зээлийн хэрэгцээ /ирэх 3 сард/




**Хадгаламжийн хандлага:** Өмнөх улирлын түүвэр судалгааны үр дүнгээр иргэд өрхийн хадгаламж ирэх 3 сард өснө гэсэн мужид байсан бол энэ улиралд иргэдийн хандлага буурна гэсэн муж руу шилжлээ /Зураг 3.8/. Судалгаанд оролцогчдын 54% нь хадгаламж эзэмшдэг бөгөөд ирэх 3 сард 12% нь хадгаламжаа бууруулах буюу хадгаламжаасаа хэрэглээнд зарцуулахаар төлөвлөж байна. Харин 31% нь хэвээр нь хадгалж, 6% нь хадгаламжаа нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Зураг 3.8 | Өрхийн хадгаламжийн талаарх хүлээлт /ирэх 3 сард/



Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд удаан эдэлгээтэй бараа худалдаж авахад тохиромжтой эсэхийг асуухад иргэдийн 60% нь тохиромжгүй, 19% нь тохиромжтой гэж хариулсан байна /Зураг 3.9/.


Зураг 3.9 Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд удаан эдэлгээтэй бараа худалдаж авахад тохиромжтой эсэх




## ХАВСРАЛТ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 60% нь эмэгтэй, 40% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 1% нь 18-25, 16% нь 26-35, 32% нь 36-45, 21% нь 46-55, 30% нь 55-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна /Зураг 1, Зураг 2/.

Зураг 1: Хүйс




Зураг 2: Нас




Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Мөн судалгаанд оролцогчидын 51% нь дээд, 33% нь бүрэн дунд боловсролтой бөгөөд 64% нь сард дунджаар 900,000.0-3,000,000.0 төгрөгний цалин авдаг байна /Зураг 3, Зураг 4/.

Зураг 3: Боловсролын түвшин



Зураг 4: Сарын дундаж цалин



Эх сурвалж: Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа



## ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНД ОРОЛЦСОН 1030 ИРГЭДИЙН САНАЛ

<b>ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ САНАЛ</b>	<b>Саналын тоо</b>
<b>Үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлд</b>	<b>352</b>
▪ Хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах	344
▪ Шатахууны үнийг тогтворжуулах	4
▪ Тээврийн зардалд хяналт тавих	4
<b>Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлд</b>	<b>86</b>
▪ Ажлын байр бий болгож, ажиллах хүчээ тогтворжуулах	31
▪ Цалин өсгөх, цагийн ажлыг олшруулах	44
▪ Тэтгэвэр нэмэгдүүлэх	11
<b>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд</b>	<b>73</b>
▪ Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих	68
▪ Үйлдвэрлэгч нарт зээл олгож, үйл ажиллагааг дэмжих	5
<b>Татварын хэмжээг бууруулах чиглэлд</b>	<b>49</b>
▪ Татварын таатай орчин нөхцөлөөр хангах	43
▪ НД-ын шимтгэлийг бууруулах	4
▪ Гаалийн татвар багасгах	2
<b>Гадаад харилцааг өргөжүүлж, гадаад худалдааг эрчимжүүлэх чиглэлд</b>	<b>31</b>
▪ Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх	16
▪ Хил гаалийн асуудлыг шийдвэрлэх	9
▪ Монгол Улсын гадаад харилцааг өргөжүүлэх, хоёр хөрштэйгөө найрсаг харилцаатай байх	3
▪ Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	3
<b>Бусад</b>	<b>81</b>
▪ Төр засаг ажлаа сайн хийх	20
▪ Хууль хэрэгжилтийг сайжруулах	14
▪ Чанартай, томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	12
▪ ШӨХТГ үнэд хяналт тавих	7
▪ Авлигатай тэмцэж, бууруулах, хүнд суртлыг арилгах	6
▪ Дамын худалдаанд хяналт тавих	5
▪ Амьжиргааны түвшинг сайжруулах	5
▪ Төр тогтвортой байх	4
▪ Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах	3
▪ Халамжийг багасгаж, зөв хүнд нь хуваарилах	3
▪ Төрийн оролцоог багасгах	2
<b>МОНГОЛБАНКНААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ</b>	
<b>Инфляц</b>	<b>65</b>
▪ Үнэ тогтворжуулах	65
<b>Зээлийн хүү ба зээл олголт</b>	<b>45</b>
▪ Зээлийн хүүг бууруулах	36
▪ ЖДҮ дэмжин хөнгөлөлттэй зээл олгох	5
▪ Зээл олгох	4
<b>Бусад</b>	<b>114</b>
▪ Валютын ханшийг тогтвортой байлгах	96
▪ Оновчтой нэгдсэн бодлого хэрэгжүүлэх	18